Хөхний хорт хавдартай өвчтөнүүдэд хими эмчилгээний дараах зүрхний диастолын үйл ажиллагааны алдагдлыг зүрхний хэт авиан шинжилгээгээр үнэлэх нь

С.Пагмадулам[1], Б.Нямгэрэл[1], Н.Баясгалан[1], В.Бямбасүрэн[1]

[1]АШУҮИС, АУС, Зүрх судалалын тэнхим

Үндэслэл: Хөхний хорт хавдрын эсрэг хими эмчилгээ гарснаар хорт хавдартай өвчтөнүүдийн амьдрах чадвар сүүлийн жилүүдэд нэмэгдэх болсон. Гэсэн хэдий ч хавдрын эсрэг үйлдэлтэй шинэ эмнүүд нь зүрх судасны системд гаж нөлөө үзүүлэх болсон.

Зорилго: ХСҮТ-д хими эмчилгээ хийлгэж байгаа хөхний хорт хавдартай өвчтөнүүдийн зүүн ховдлын диастолын үйл ажиллагааг үнэлэхэд оршино.

Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгааг агшингийн болон тууш судалгааны загвараар хөхний хорт хавдрын эсрэг хими эмчилгээ хийлгэж байгаа 36 (47±9.3 нас) эмэгтэйг хамруулан 2019.07 сараас 2019.10 сарын хооронд ХСҮТ-д хийж гүйцэтгэсэн. Бүх өвчтөнүүдэд асуумж, үзлэг, ЗЦБ, болон зүрхний хэт авиан шинжилгээг 3 курс хими эмчилгээний (3 сар) өмнөх болон дараах байдлаар 2 удаагийн давтамжтай үнэлж үзүүлэлтүүдийг хооронд нь харьцуулсан.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан 36 өвчтөнөөс эхний үзлэгээр 15 (42%) өвчтөн диастолын үйл ажиллагааны 1-р зэргийн алдагдалтай байсан. Үүнээс 3 курс хими эмчилгээний дараа бүх өвчтөнүүдийн 26 (72%)-д диастолын үйл ажиллагааны алдагдал оношлогдсон буюу эхний үзлэгээр диастолын үйл ажиллагааны алдагдалгүй байсан 21 өвчтөний 11 (52%)-д диастолын үйл ажиллагааны алдагдал шинээр илэрсэн. Диастолын үйл ажиллагааны алдагдалтай өвчтөнүүдийн 92% нь эмчилгээнд антрациклин хэрэглэсэн байсан. Эдийн доплероор E/e/ ба E/A харьцаа нэмэгдсэн ($p<0.05$).

Дүгнэлт: 3 курс хими эмчилгээний дараа 11 өвчтөнд шинээр диастолын үйл ажиллагааны алдагдал оношдогдсон. Антрациклин хэрэглэсэн өвчтөнүүдэд диастолын үйл ажиллагааны алдагдал нийтлэг тохиолдож байна.

Түлхүүр үг: Диастолын үйл ажиллагааны алдагдал, хөхний хорт хавдар, антрациклин эмчилгээ

ЭРҮҮЛ

Evaluating diastolic dysfunction by TTE among breast cancer patients undergoing chemotherapy

Pagmadulam S[1], Nyamgerel B[1], Bayasgalan.N[1], Byambasuren V[1]

[1]Department of Cardiology, MNUMS

Introduction: Chemotherapy has shown great progress last decades, leading to the gradual increase in the survival of cancer patients. However along with this benefit, the cardiovascular side effects of modern anticancer agents have also proven to be an increasing problem.

Purpose: Assessing diastolic dysfunction among breast cancer patients undergoing chemotherapy in National Cancer Center Mongolia.

Materials and methods: This cross-sectional, longitudinal study comprised 36 (47.3±9.3 age) consecutive female patients receiving chemotherapy for breast cancer between July 2019 and October 2019. All patients underwent questionnaire, clinical evaluation, and echocardiogram two visits at 3 months after and before chemotherapy. We performed transthoracic echocardiography to measure E/A, E/E/, IVRT, DT and S/D.

Results: 15 (42%) out of the 36 patients had type I diastolic dysfunction in the first visit. Whereas 11 (52%) out 21 patients (without diastolic dysfunction in the first visit) had diastolic dysfunction newly diagnosed via echocardiography. The 92 % of the newly diagnosed diastolic dysfunction group was using anthracyclines. There was significant increase in the tissue Doppler early filling velocity (E/E/) ratio, DT and IVRT and decrease E/A ($p<0.05$).

Conclusion: Diastolic dysfunction was newly diagnosed in 11 patients undergoing 3 courses of chemotherapy. The incidences were higher among the patients using anthracyclines and trastuzumab.

Keywords: Diastolic dysfunction, Breast cancer, Anthracycline chemotherapy